



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг-Япон Улсын Шизуока мужийн Яйзү хот хоорондын найрамдалт хамтын ажиллагааг бататган бэхжүүлэх, хоёр орны соёлыг түгээн сурталчлах зорилгоор Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх “Хайрхан хөгжлийн төв”-ийн барилгаас “Эрдмийн задгай театр” хүртэлх чулуун зам бүхий гудамжийг “Яйзү хотын нэрэмжит гудамж” болгох саналыг дэмжиж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР